



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 5/08

Эрдэнэт

Хорооны дарга сонгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв, санхүүгийн хөгжлийн хороо, Нийгмийн хөгжлийн хорооны саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв, санхүүгийн хөгжлийн хорооны дарга С.Ганцогт, Нийгмийн хөгжлийн хорооны дарга Ц.Баяржаргал нарыг гаргасан хүсэлтийн дагуу хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв, санхүүгийн хөгжлийн хорооны даргаар төлөөлөгч Б.Отгонбатыг, Нийгмийн хөгжлийн хорооны даргаар төлөөлөгч Д.Батбаяр нарыг тус тус сонгож баталсугай.

ДАРГА



П.ПҮРЭВЛХАГВА